



**СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 03

Баруун-Урт

Үндсэн чиглэл батлах тухай


Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 18 дугаар зүйлийн 18.1.2 “а”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын ээлжит 3 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2016 оны Үндсэн чиглэлийг 80 хувийн биелэлттэй гэж дүгнэсүгэй.

Хоёр. Төлөөлөгчдөөс гаргасан саналуудыг тусган “Аймгийн Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

Гурав. Үндсэн чиглэлийг Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөрүүдтэй нягт уялдуулан хэрэгжүүлж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга, холбогдох агентлаг, албадын дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ГАНСҮХ